



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/368

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай” хөтөлбөрийн 2.2.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийн 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2.4.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Чингис хааны цом-2019” олон улсын мэргэжлийн тогоочдын ур чадварын уралдаанд орон нутгийн хоол үйлдвэрлэгчдийг оролцуулахад шаардагдах зардалд 2 160 000 (хоёр сая нэг зуун жаран мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх 2 160 000 (хоёр сая нэг зуун жаран мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100594

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 29-ны өдрийн А/368 дугаар
захирамжийн хавсралт

“ЧИНГИС ХААНЫ ЦОМ-2019” ОЛОН УЛСЫН ТОГООЧ НАРЫН
УР ЧАДВАРЫН УРАЛДААНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

	Зардлын нэр	Тоо , ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Уралдаанд оролцох тогоочын дүрэмт хувцас	6	120 000	720 000
2	Уралдаанд оролцох мандатын үнэ	8	180 000	1 440 000
	Нийт			2 160 000

-оОо-